

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ, ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН /2022 оны III улирлын байдлаар/**

№	Ажлын чиглэл	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Биелэлтийн хувь	Биелэлт дутагдалтай байсан бол түүний шалтгаан
1	Хүний нөөцийн чиглэлээр	<p>Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, 21 аймаг, нийслэлийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт нийт 944 төрийн албан хаагч ажиллаж байгаагаас 23 Ёс зүйн салбар зөвлөлүүдэд 110 албан хаагчид ажиллаж байна. Эдгээр төрийн албан хаагчдын ажилласан жил дунджаар 13.4 байна.</p> <p>Ёс зүйн зөвлөлийн албан хаагчид байгууллагадаа, салбарт ёс зүйн зөв хандлага, хариуцлага, төлөвшлөөр сургах, манлайлах, нөлөөлөх, албан хаагчдыг авилга, албан тушаалаа урвуулан ашиглах, ёс зүйн зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэх, хүний нөөцийн удирдлагыг төлөвшүүлэх зэрэг чиглэлээр тодорхой сургалт, арга хэмжээ зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Хүний нөөцийн талаар: Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар сул орон тоо нөхөх, албан хаагчдын цалингийн шатлал тогтоох, ажилласан жилийг тооцон олгохдоо Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчдын тусгай шалгалт зохион байгуулах журам болон бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2022 онд 5 удаагийн хуралдааныг зохион байгуулж 7 асуудлыг шийдвэрлэн 7 тогтоол гарган хэрэгжилтийг хангуулсан байна. Яам, агентлагт 5 сул орон тоог нөхөхөөр 2 удаагийн сонгон шалгаруулалтыг олон нийтэд нээлттэй зарлаж зохион байгуулсан.</p> <p>2022 онд нийт хүний нөөцийн холбогдолтой 85 тушаал гаргаснаас: Томилсон- 28; Чөлөөлсөн -24; Буцалтгүй тусламж-2; Сахилгын шийтгэл-3; Зэрэг дэвийн нэмэгдэл олгох-2; Бусад -26 тушаалыг тус тус гаргасан. Тушаалын хэрэгжилт бүрэн хангагдсан.</p>	100	

		<p>Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийн шийдвэрээр Барилга, хот байгуулалтын яамны сайдын 66 дугаар Төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай тушаалаар яам болон агентлагын 20 албан хаагчдын зэрэг дэвийг нэмэгдүүлсэн. Үүнд:</p> <p>Ахлах түшмэлийн тэргүүн зэрэг-1 албан хаагч; Ахлах түшмэлийн дэд зэрэг-2 албан хаагч; Ахлах түшмэлийн гутгаар зэрэг-1 албан хаагч; Ахлах түшмэлийн дөтгөөр зэрэг-5; Дэс түшмэл тэргүүн зэрэг-2; Дэс түшмэлийн дэд зэрэг-2; Дэс түшмэлийн гутгаар зэрэг-5 албан хаагч; Дэс түшмэлийн дөтгөөр зэрэг -2 албан хаагчид тус тус зэрэг дэвийн нэмэгдлийг олгуулсан.</p> <p>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 22 дугаар тушаалаар баталсан “Стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т заасны дагуу нийт 10 нэгж, нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймагт Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумдад газрын даамал гэсэн нэгжтэйгээр ажиллаж байна.</p> <p>Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл жагсаалтыг агентлагийн даргын 2019 оны Б/123 дугаар тушаалаар шинэчлэн баталсан бөгөөд 21 аймгийн ГХБХБГ-т нийт 762 албан хаагч ажиллаж байна.</p> <p>ГЗБГЗЗГ-ын дарга, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2022 оны А/42, А/211 дүгээр тушаал, захирамжаар нийслэлийн Газар зохион байгуулалтын албыг 10 хэлтэс, 9+2 дүүргийн ГЗБА-ны бүтцийг тогтоож, Газрын даргын 2022 оны Б/22 дугаар тушаалаар зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал, зэрэглэлийг шинэчлэн баталсан.</p> <p>Батлагдсан албан тушаалын дагуу Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 348 дугаар тогтоолоор Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 358, 359 дүгээр тогтоолын хавсралтын нэгжийн нэр өөрчлөх- 23, мэргэжил хэсэгт өөрчлөлт оруулах-31, туршлага хэсэгт өөрчлөлт оруулах 28 албан тушаалын тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулах тухай зөвшөөрөл олгогдсоны дагуу албаны даргын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/72 дугаар тушаалаар албан тушаалын тодорхойлолтыг баталсан байна.</p>		
--	--	--	--	--

		<p>Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах, батлуулах ажлыг 21 аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн санал, мөн хүн амын тоо, газрын нэгж талбарын тоо, холбогдох судалгаа мэдээлэлд түшиглэн танилцуулга бэлтгэн Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар танилцуулан Барилга, хот байгуулалтын сайдад уламжилсан.</p> <p>Тус газрын сул орон тоонд 32 иргэнийг нэр дэвшүүлэн Авлигатай тэмцэх газарт хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар албан бичиг хүргүүлж, тухайн албан тушаалд томилон ажиллуулж байна.</p> <p>Байгаль орчин, аялал жуулчлалын яам-1, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба-3, Хот байгуулалт, хөгжлийн газар-4, Замын хөгжлийн газар-1 удирдлагуудтай шилжүүлэн томилох асуудлаар зөвшилцөн албан тушаалд томилон ажиллуулсан.</p> <p>Сул болон түр эзгүй байгаа орон тоо гарсан тохиолдолд “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Шатлан дэвшүүлж томилсон-7 2. Төрийн жинхэнэ албаны сонгон шалгаруулалтаар тусгай шалгалт өгч томилогдсон-4 3. Түр орон гүйцэтгэгч-10 4. Түр эзгүй байгаа орон тоонд-3 5. Төрийн жинхэнэ албан хаагчийг удирдлагын хооронд харилцан тохиролцсны дагуу шилжүүлэн томилсон-9 6. Хүүхэд асрах чөлөөний хугацаагаа дуусган ажилдаа орсон-2. <p>Төрийн жинхэнэ албаны 3 сул орон тоог Төрийн албаны зөвлөлийн барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлд 2022.05.27-ны өдрийн 1/1055 тоот албан бичгээр хүргүүлж, зарлагдаж нөхсөн.</p> <p>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах зорилгоор сул орон тооны зарыг цахим хуудсанд тухай бүр байрлуулан олон нийтэд мэдээлсэн.</p> <p>ГЗБГЗЗГ-ын албан хаагчдын ажилласан жилийн дэлгэрэнгүй судалгааг Төрийн үйлчилгээний цахим системээс нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх мэдээллийг авч бэлтгэсэн.</p>		
--	--	--	--	--

		<p>2022 оны цалингийн санг 2022.01.18-ны өдрийн Б/13 дугаар тушаалаар шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Тус газрын үндсэн 83 албан хаагч, гэрээт 16 албан хаагчийн цалингийн мэдээллийг тухай бүр оруулж байна.</p> <p>Албан хаагчдын цаг ашиглалтад хяналт тавьж, цагийн бүртгэлийг сард 2 удаа СЭЗХ-т гаргаж байна.</p> <p>Албан хаагчдын мэдээллийг “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн систем”-д 85 албан хаагчийн дэлгэрэнгүй мэдээллийг шинэчилсэн бүртгэлд оруулсан.</p> <p>Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд 21 аймгийн оруулсан мэдээлэлд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Мөн 2022 оны 05 дугаар сард нийт 83 албан хаагчдын дараах мэдээллийг цахим системд шинэчлэн оруулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Улсын код”-ын мэдээлэл, 2. “Ажил мэргэжлийн код”-ын мэдээлэл, 3. “Ажилтны ангилал”-ын мэдээлэл. <p>Цахим системийн шинэчлэлийн хүрээнд ТАЗ-аас зөвлөмж авч, 80 албан хаагчийн мэдээллийг дахин шинэчилэн орууллаа.</p> <p>Шинээр томилогдсон, чөлөөлөгдсөн, шилжин ажилласан нийт 49 албан хаагчийн мэдээллийг системд бүртгэж оруулах, хасах ажлыг гүйцэтгээд байна.</p> <p>2022 сургалт, хөгжлийн төлөвлөгөөг 4 дэд хэсэгт 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, боловсруулж тус газрын даргын 2022 оны А/39 дүгээр тушаалаар батлагдсан.</p> <p>Батлагдсан төлөвлөгөөг 21 аймгийн ГХБХБГ, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд тус газрын даргын 2022.02.18-ны өдрийн 1/294 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>2022 оны сургалт хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт:</p> <p>Нэг. Уулзалт, зөвлөгөөн</p> <ul style="list-style-type: none"> • Хэрэгжүүлэх арга хэмжээ-3 • Хэрэгжсэн-2 • Хугацаа болоогүй-1 		
--	--	---	--	--

		<p>Хоёр. Аймгийн ГХБХБГ, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны албан хаагч, сумын газрын даамлуудад зориулсан сургалт</p> <ul style="list-style-type: none"> • Хэрэгжүүлэх арга хэмжээ-20 • Хэрэгжсэн-19 • Хугацаа болоогүй-1 <p>Увс, Сүхбаатар, Завхан, Өмнөговь аймгуудаас ирүүлсэн захиалгын дагуу цахим сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан.</p> <p>Гурав. Агентлагийн албан хаагчдад зориулсан сургалт</p> <ul style="list-style-type: none"> • Төлөвлөсөн арга хэмжээ-26 • Хэрэгжсэн-21 • Хугацаа болоогүй-5 <p>2022 оны сургалт хөгжлийн төлөвлөгөөг Газрын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд улирал, сараар хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. 2022 оны Удирдлагын академид Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэх сургалт, судалгааны ажлын төлөвлөгөөний 5.3-д заасан Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ “Алсын хараа-2050” сэдэвт богино хугацааны зайн сургалтад-3 албан хаагч, 2. "Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 3 албан хаагч, 3. Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2 албан хаагч, 4. “Ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 3 албан хаагч, 5. Богино хугацааны захиалгат сургалтыг Удирдлагын академийн Мэргэшил дээшлүүлэх институтэд “Төрийн захиргааны удирдлага ба гүйцэтгэлийн төлөвлөлт” сургалтад 21 аймгийн ГХБХБГ-ын Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтнүүдийг 2022 оны 04 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд 45 албан хаагч оролцсон. 6.Богино хугацааны захиалгат сургалт “Төрийн албаны хүний нөөцийн удирдлага ба сургалтын тогтолцоо”, төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтад 1 албан хаагч, 7."Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны зохицуулалтын шинэчэл" сэдэвт сургалтад 3 албан хаагч, 8."Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийг чадавхжуулах сургалт"-д хамрагдах 1 албан хаагчийг хамруулсан байна. 		
--	--	---	--	--

		<p>2022 оны албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний төслийг 6 үндсэн зорилтын хүрээнд 27 арга хэмжээг төлөвлөн боловсруулж, батлуулсан. Төлөвлөгөөг 21 аймгийн ГХБХБГ, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд тус газрын даргын 2022.02.18-ны өдрийн 1/294 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр дүгнэх, мэдээлэл, судалгааг цаг хугацаанд нь гарган ирүүлж байхыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга нарт үүрэг болгосон.</p>		
2	Гомдол мэдээллийн, ёс зүйн зөрчлийн судалгаа	Яам, агентлагийн хэмжээнд 2022 онд ёс зүйн гомдол, зөрчил гараагүй болно.	-	
3	Ёс зүйн зөрчлүүдийн шийдвэрлэлтийн үр нөлөө	Өмнөс онд гарсан ёс зүйн зөрчил, гомдлын шийдвэрлэлт, авилга, албан тушаалаа урвуулан ашиглах, ёс зүйн зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, соён гэгээрүүлэх арга хэмжээнүүдийн үр дүнд 2022 онд зөрчил, гомдол бүртгэгдээгүй.	100	
4	Сургалт, соён гэгээрэл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлээр	<p>Сургалтын чиглэлээр: БХБЯ, ЖАЙКА, КОЙКА зэрэг олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудтай хамтран 18 сургалтуудыг 2022 оны III улирлын байдлаар зохион байгуулж, давхардсан тоогоор 355 албан хаагчдыг хамруулаад байна.Тухайлбал:</p> <ol style="list-style-type: none"> 1. Засгийн газрын “Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2022.1.5-ны өдрийн 7 дугаар тогтоолын 5 дахь заалтыг хэрэгжүүлэхээр яамны албан хаагчдад үндэсний монгол бичгийн сургалтыг 4 дүгээр сарын 11-нээс 5 дугаар сарын 2-нд явуулж, 62 албан хаагчдыг; 2. 4 дүгээр сарын 5-ны өдрийн “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” сэдэвт сургалтад 53 албан хаагчдыг; 3. БХБЯ-ны үйл ажиллагаанд Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэхтэй холбоотой 8 удаагийн сургалтад давхардсан тоогоор 163 албан хаагчдыг; 4. Монгол Улсын хөгжлийн бодлого: төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ “АЛСЫН ХАРАА - 2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” сургалтад яам, харьяа байгууллагаас 99 албан хаагчдыг; 5. Бүгд Найрамдах Сингапур Улсын Орон сууцны байгууллагатай хамтран 10 дугаар сард зохион байгуулсан “Орон сууцны санхүүжилтийн шийдэл” сургалтад 40 албан хаагчдыг; 	100	

		<p>6. Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага КОЙКА-аас 2022.4.11-15-ны өдрүүдэд цахимаар “Үндэсний тэнцвэртэй хөгжлийн төлөөх бүс нутгийн бодлого, төлөвлөлтийн чиглэлд хүний нөөцийг хөгжүүлэх” сургалтад 20 албан хаагчдыг;</p> <p>7. Японы Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (ЖАЙКА)-ийн шугамаар 9 дүгээр сарын 26-наас 10 дугаар сарын 7-нд цахим, 10 дугаар сарын 8-28-ны өдрүүдэд танхимаар Япон улсад “Үндэсний болон бүс нутгийн хөгжлийн бодлого” сургалтад 1 албан хаагчийг;</p> <p>8. БНСУ-ын их сургуулийн дэд бүтцийн магистрын 2022-2024 оны бүрэн тэтгэлэгт хөтөлбөрт 1 албан хаагчийг;</p> <p>9. БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /КОЙКА/-аас 2022-2023 оны “Public Management and Public Sector Reforms” магистрын бүрэн тэтгэлэгт хөтөлбөрт 1 албан хаагчийг тус тус хамруулсан.</p> <p>Төрийн албаны зөвлөлөөс “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагын өөрчлөлт, бүтээмжийг дэмжих” жил болгон зарласантай холбогдуулан долоо хоног бүрийн “Пүрэв” гарагийн вэбинар сургалтын линкийг яам, агентлагийн 100 гаруй албан хаагчдад өгч, сургалтад хамруулж байна.</p> <p>Ёс зүйн зөвлөлийн албан хаагчид байгууллагадаа, салбарт ёс зүйн зөв хандлага, хариуцлага, төлөвшлөөр сургах, манлайлах, нөлөөлөх зэрэг чиглэлээр ажиллаж байна.</p> <p>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүй, хот байгуулалтын салбарын чиглэлээр 2022 оны эхний хагас жилд 46 сургалтад аймаг, нийслэлийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2459 /давхардсан тоогоор/ төрийн албан хаагчдыг хамруулсан. Тухайлбал:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт” сургалтад 40 албан хаагчдад; 2. “Геопорталын хэрэглээ” сургалтыг 3 дугаар сарын 15-наас 18-ны өдрүүдэд 21 аймаг, нийслэлийн геодези зураг зүйн мэргэжилтнүүдэд; 3. “Хот байгуулалтын кадастрын цахим системийн хэрэглээ” сургалтыг 2 дугаар сарын 11-ны өдөр 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын холбогдох албан хаагчид, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны холбогдох албан хаагчдад; 4. “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-ийн хэрэглээ” сургалтыг 4 дүгээр сарын 21-нд Аймаг, нийслэлийн ерөнхий архитекторууд, Газрын харилцаа, 		
--	--	---	--	--

		<p>барилга, хот байгуулалтын газрын холбогдох албан хаагчид, сумын газрын даамлуудад зориулан тус тус зохион байгуулсан.</p> <p>Мэргэжлийн болон бусад чиглэлийн 50 удаагийн сургалтуудад давхардсан тоогоор 2,577 төрийн албан хаагчдыг хамруулсан.</p> <p>Ёс зүйн чадамжийг дээшлүүлэх чиглэлээр: Төрийн албаны зөвлөл, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөлд 2022 онд сонгогдсон БХБЯ-нд “Стратегийн баримжаатай хүний нөөцийн удирдлага”, “Ёс зүйн зөвлөлийг бэхжүүлэх нь” дэд төслүүдийг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд хийгдэх ажлуудаа БХБЯ-ны дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн 2022 оны үйл ажиллагаа, сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг зохион байгуулж байна.</p> <p>Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> - Албан хаагчдын ёс зүйн чадамжийг дээшлүүлэх хүрээнд яамны гүйцэтгэх түвшний албан хаагчдад 2022 оны 5 дугаар сарын 23, 6 дугаар сарын 17-ны өдрүүдэд “Албан хаагчийн шударга, зарчимч байдлыг нэмэгдүүлэх нь” сэдэвт; - 9 дүгээр сарын 6-нд яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Барилгын хөгжлийн төв, “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК-ийн удирдах шатны албан хаагчдад зориулсан “Удирдах албан хаагчийн ёс зүйн манлайлал” сургалт-хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан. Сургалт-хэлэлцүүлэгт 152 албан хаагчдыг хамруулсан. - Албан хаагчдын ёс зүйн чадамжийг бэхжүүлэх сургалтыг 9 дүгээр сарын 23-ний өдөр зохион байгуулж, нийт 56 албан хаагч хамрагдсан. Архангай аймгийн ГХБХБГ-ын албан хаагч, сумдын газрын даамлууд нийт 40 албан албан хаагчдыг тус тус хамруулсан. - Яамны албан хаагчид хоорондын найрсаг харилцаа, хандлагыг хөгжүүлж, сэтгэл ханамж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилго бүхий “Талархлын аян”-ыг зохион байгуулсан. Энэ үеэр 200 гаруй талархал илэрхийлсэн зурвасуудаар бие биедээ урам өгч, сайхан сэтгэгдэлийг төрүүлээ. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, Ёс зүй зөвлөлийн ажиллах журамд нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. - Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөрт яам, харьяа байгууллагуудын 11 эмэгтэй албан хаагчдыг хамруулсан. - Яаманд шинээр ажилд орсон төрийн албан хаагчийн хөгжлийн суурийг тавих, чадавхийг төлөвшүүлэх, дадлага туршлага хуваалцах, чиглүүлэх зөвлөх зорилгоор Менторшип хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрт 18 албан хаагчид оролцсон. 		
--	--	---	--	--

		<ul style="list-style-type: none"> - Газрын салбарын удирдах ажилтны 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн зөвлөгөөнд 21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны удирдах ажилтнуудад, Төв аймгийн ГХБХБГ-аас 2022 оны 03 сарын 09-11-ний өдөр зохион байгуулсан сумын Газрын даамлуудад зориулсан сургалтад “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр байгууллагын Ёс зүйн зөвлөлийн дарга Л.Лувсан илтгэл тавьсан. - Мөн Өмнөговь аймгийн ГХБХБГ-аас 2022 оны 03 сарын 11-ний өдөр зохион байгуулсан сумын Газрын даамлуудад зориулсан сургалтад Ёс зүйн зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Мөнхзул “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр цахимаар илтгэл тавьж оролцсон. - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн 2022 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу албан хаагчдын дунд төрийн албан хаагчид болон бусад ажилтнуудын ёс зүйн талаарх ойлголт, мэдлэгийн талаар, мөн байгууллагын албан хаагчдад шаардлагатай сургалтын хэрэгцээг тодорхойлох зорилгоор судалгаа хийсэн. Судалгаанд нийтдээ 1 сараас 30 жил ажилласан 52 албан хаагч оролцсон байна. Судалгааны дүнг нэгтгэн удирдлагад танилцуулав. - Тус Ёс зүйн зөвлөлөөс 2022 онд төрийн захиргааны албан тушаалд шинээр томилогдсон 3 албан хаагчдад туршилтын хугацаанд ажиллах хугацаанд ёс зүйн зөрчил гаргасан эсэх дүгнэлт гаргах ажлыг хийж гүйцэтгэлээ. - “Газрын харилцааны салбарын ёс зүйн дүрэм”-ийг шинээр, “Байгууллагын Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг шинэчлэн боловсруулж, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас санал авч, Газрын даргын дэргэдэх Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. <p>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн, барилга, хот байгуулалтын салбарын төрийн албан хаагчдыг авилга, албан тушаалыг урвуулан ашиглах, ёс зүйн зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэх, хүний нөөцийн удирдлагыг төлөвшүүлэх зорилгоор яам, агентлаг дангаараа болон төслийн багтай хамтран зохион байгуулсан 8 удаагийн сургалтад 280 албан хаагчдыг хамруулсан. Эдгээр соён гэгээрүүлэх сургалт, арга хэмжээний үр дүнд 2022 онд ёс зүйн зөрчил, гомдол бүртгэгдээгүй.</p>		
--	--	---	--	--

-----***-----